



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын нэгдсэн эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/246-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сүхбаатар сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 70363047 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал, дүгнэлт	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4-13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14-15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Материаллаг байдал	15-16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	16-17
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17-19
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	19
3.8 Аудитын гол асуудал	19
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.	19-20
3.10 Өмнөх оны акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	20
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
4. Аудитын илрүүлэлт	20-22
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМЯ	Эрүүл мэндийн яам



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № СЭА-2022/246-НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН МАНДАЛ СУМЫН
НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ДАРГА
Ё. БУЯНДЭЛГЭР ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын Нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	256,649,930.65	556,507,886.40
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		2,539,011.21
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	2,539,011.21
3121	Төгрөг	-	2,539,011.21
31211	Төрийн сангийн харилцах	-	2,373,974.21
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	165,037.00
33	АВЛАГА	-	336,906,517.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	336,906,517.00
35	БАРАА МАТЕРИАЛ	256,649,930.65	217,062,358.19
351	Түүхий эд материал	123,581,656.72	89,979,090.04
35110	Тусгай зориулалттай материал	1,719,800.00	517,250.00
35130	Эм боох материал	121,861,856.72	89,461,840.04
354	Хангамжийн материал	133,068,273.93	127,083,268.15
35420	Аж ахуйн материал	73,662,910.00	80,879,450.00
35430	Сэлбэг хэрэгсэл	21,059,223.93	26,335,902.65
35450	Барилгын засварын материал	99,500.00	11,500.00
35460	Хүнсний материал	19,811,490.00	2,455,065.50
35470	Бусад хангамжийн материал	16,765,150.00	17,401,350.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,453,483,843.78	4,831,599,925.63
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,453,483,843.78	4,831,599,925.63
392	Биет хөрөнгө	4,344,847,843.78	4,722,713,092.30
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,325,666,046.14	3,325,666,046.14
39202	Хуримтлагдсан элэгдэл	(272,069,939.43)	(408,236,013.99)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	299,008,111.00	330,252,444.40
39204	Хуримтлагдсан элэгдэл	(167,246,750.14)	(168,048,509.60)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,908,090,455.18	2,000,699,450.77
39206	Хуримтлагдсан элэгдэл	(861,290,381.24)	(489,283,344.79)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	193,929,343.11	155,223,421.21

39208	Хуримтлагдсан элэгдэл	(101,520,252.02)	(40,012,179.26)
39209	Зам, гүүрийн байгууламж	33,425,059.06	33,425,059.06
39210	Хуримтлагдсан элэгдэл	(13,713,747.88)	(17,543,181.64)
39217	Ном	569,900.00	569,900.00
393	Биет бус хөрөнгө	108,636,000.00	108,886,833.33
39301	Програм хангамж	430,000.00	258,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(430,000.00)	(7,166.67)
39303	Бусад биет бус хөрөнгө	108,636,000.00	108,636,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,710,133,774.43</u>	<u>5,388,107,812.03</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>544,225,579.08</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	544,225,579.08
413	Өглөг	-	544,225,579.08
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	242,798,352.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	301,427,227.08
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,710,133,774.43</u>	<u>4,843,882,232.95</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,710,133,774.43	4,843,882,232.95
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,347,393,178.65	1,347,393,178.65
51101	Өмч: - төрийн	1,347,393,178.65	1,347,393,178.65
512	Хуримтлагдсан үр дүн	595,567,564.64	729,316,023.16
51210	Өмнөх үеийн үр дүн	595,567,564.64	595,567,564.64
51220	Тайлант үеийн үр дүн	-	133,748,458.52
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,767,173,031.14	2,767,173,031.14
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,710,133,774.43</u>	<u>5,388,107,812.03</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,383,768,654.00	7,383,572,125.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	50,110,924.00	1,184,741,192.20
120	Нийтлэг татварын бус орлого	50,110,924.00	790,049,931.53
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	50,110,924.00	447,822,312.57
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	48,880,264.00	141,158,109.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,230,660.00	1,390,300.00

120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-бараа материал		305,273,903.57
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн хөрөнгө		342,227,618.96
120005	Тусламжийн орлого	-	394,691,260.67
120005	Хандив тусламж /дотоод/	-	394,691,260.67
120005	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,333,657,730.00	6,198,830,933.30
120005	Нэмэлт санхүүжилтийн орлого	170,276,444.00	619,907,145.00
120005	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	32,324,000.00	30,000,000.00
120005	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,838,066.00	265,000,000.00
120005	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	131,875,937.00	289,830,890.00
120005	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,238,441.00	35,076,255.00
120005	Төсвийн захирагчдаас	-	340,000,000.00
120005	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	-	340,000,000.00
120005	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,001,466,586.00	5,238,923,788.30
120005	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	2,001,466,586.00	5,238,923,788.30
120005	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,815,757,340.43	7,249,823,666.98
120005	УРСГАЛ ЗАРДАЛ	5,815,757,340.43	7,249,823,666.98
120005	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,775,564,003.41	6,985,023,666.98
120005	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,073,646,754.16	3,636,350,028.09
120005	Үндсэн цалин	2,032,029,005.74	1,502,898,655.00
120005	Нэмэгдэл	728,647,793.63	1,812,174,389.19
120005	Унаа хоолны хөнгөлөлт	123,701,305.90	111,443,778.71
120005	Урамшуулал	189,268,648.89	209,833,205.19
120005	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	385,348,710.82	464,502,422.00
120005	Тэтгэврийн даатгал	265,796,981.82	330,022,749.00
120005	Тэтгэмжийн даатгал	30,957,970.00	33,864,443.00
120005	ҮОМШӨ-ний даатгал	22,552,491.00	27,110,182.00
120005	Ажилгүйдлийн даатгал	6,034,851.00	6,682,276.00
120005	Эрүүл мэндийн даатгал	60,006,417.00	66,822,772.00
120005	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	509,118,108.00	548,408,533.00
120005	Гэрэл, цахилгаан	69,067,402.00	62,897,165.00
120005	Түлш, халаалт	299,582,700.00	344,369,025.00
120005	Цэвэр, бохир ус	140,468,006.00	141,142,343.00
120005	Хангамж, бараа материалын зардал	96,197,047.00	147,749,731.00

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Нэгдсэн эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

120005	Бичиг хэрэг	12,600,460.00	11,358,210.00
120005	Тээвэр, шатахуун	43,973,820.00	74,465,465.00
120005	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,692,867.00	4,974,610.00
120005	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	34,519,900.00	38,809,590.00
120005	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,410,000.00	14,907,780.00
120005	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	3,234,076.00
120005	Нормативт зардал	1,238,098,576.28	1,664,486,725.11
120005	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,101,658,968.28	1,495,793,035.61
120005	Хоол, хүнс	136,025,508.00	168,343,689.50
120005	Нормын хувцас, зөөлөн эдлэл	414,100.00	350,000.00
120005	Эд хогшил, урсгал засварын зардал	118,882,191.00	70,239,600.00
120005	Багаж, техник, хэрэгсэл	13,262,700.00	2,193,430.00
120005	Урсгал засвар	103,829,491.00	68,046,170.00
120005	Томилолт, зочны зардал	5,088,700.00	1,886,030.00
120005	Дотоод албан томилолт	5,088,700.00	1,886,030.00
120005	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,601,585.00	44,226,400.00
120005	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	31,420,000.00
120005	Даатгалын үйлчилгээ	3,237,234.00	4,327,684.00
120005	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.00	242,000.00
120005	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,423,700.00	7,268,100.00
120005	Газрын төлбөр	968,616.00	968,616.00
120005	Бараа үйлчилгээний бусад зардал	336,582,331.15	407,174,197.78
120005	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	336,222,331.15	407,174,197.78
120005	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,193,337.02	264,800,000.00
120005	Бусад урсгал шилжүүлэг	4,209,000.00	264,800,000.00
120005	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	264,800,000.00
120005	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(431,988,686.43)	133,748,458.52

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	5,383,968,654.00	6,004,472,825.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	50,110,924.00	142,548,409.00
120	Нийтлэг татварын бус орлого	50,110,924.00	142,548,409.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	50,110,924.00	142,548,409.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	48,880,264.00	141,158,109.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,230,660.00	1,390,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,333,857,730.00	5,861,924,416.30

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	170,476,444.00	619,907,145.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	32,324,000.00	30,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,038,066.00	265,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	131,875,937.00	289,830,890.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,238,441.00	35,076,255.00
1330	Төсвийн захирагчдаас	-	340,000,000.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	-	340,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,001,466,586.00	4,902,017,271.30
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	2,001,466,586.00	4,902,017,271.30
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	5,263,045,608.00	5,959,894,114.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,263,045,608.00	5,959,894,114.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,222,652,270.98	5,695,094,114.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,073,643,654.16	3,422,494,185.09
210101	Үндсэн цалин	2,032,025,905.74	1,502,898,655.92
210102	Нэмэгдэл	728,647,793.63	1,598,318,545.27
210103	Унаа хоолны хөнгөлөлт	123,701,305.90	111,443,778.71
210104	Урамшуулал	189,268,648.89	209,833,205.19
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	385,348,710.82	435,559,913.00
210201	Тэтгэврийн даатгал	265,796,981.82	301,080,240.00
210202	Тэтгэмжийн даатгал	30,957,970.00	33,864,443.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	22,552,491.00	27,110,182.00
210204	Ажилгүйдлийн даатгал	6,034,851.00	6,682,276.00
210205	Эрүүл мэндийн даатгал	60,006,417.00	66,822,772.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	509,118,108.00	547,389,039.00
210301	Гэрэл, цахилгаан	69,067,402.00	62,897,165.00
210302	Түлш, халаалт	299,582,700.00	344,299,865.00
210303	Цэвэр, бохир ус	140,468,006.00	140,192,009.00
2104	Хангамж, бараа материалын зардал	86,093,087.00	126,148,645.00
210401	Бичиг хэрэг	5,446,800.00	7,445,560.00

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Нэгдсэн эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210402	Тээвэр, шатахуун	45,889,820.00	72,934,625.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,692,867.00	4,974,610.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	29,342,200.00	36,799,250.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,721,400.00	3,994,600.00
2105	Нормативт зардал	1,030,275,035.00	1,054,449,882.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	853,360,095.00	901,621,901.00
210502	Хоол, хүнс	152,570,140.00	150,926,905.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	24,344,800.00	1,901,076.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	112,445,291.00	58,599,820.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,642,200.00	4,488,300.00
210604	Урсгал засвар	93,803,091.00	54,111,520.00
2107	Томилолт, зочны зардал	5,088,700.00	1,886,030.00
210702	Дотоод албан томилолт	5,088,700.00	1,886,030.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,279,685.00	48,566,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	31,420,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,237,234.00	4,327,684.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.00	242,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,253,700.00	7,268,100.00
210807	Газрын төлбөр	968,616.00	968,616.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	6,948,100.00	4,340,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,393,337.02	264,800,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,409,000.00	264,800,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	264,800,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	120,923,046.00	44,578,711.21
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	120,923,046.00	42,039,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	120,923,046.00	42,039,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	120,923,046.00	42,039,700.00
223001	Бусад хөрөнгө	120,923,046.00	42,039,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(120,923,046.00)	(42,039,700.00)

8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	2,539,011.21
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,539,011.21

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,347,393,178.65	2,767,173,031.14	595,567,564.64	4,710,133,774.43
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,347,393,178.65	2,767,173,031.14	595,567,564.64	4,710,133,774.43
Тайлант үеийн үр дүн	-	-	133,748,458.52	133,748,458.52
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,347,393,178.65	2,767,173,031.14	595,567,564.64	4,710,133,774.43
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,347,393,178.65	2,767,173,031.14	595,567,564.64	4,710,133,774.43
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,347,393,178.65	2,767,173,031.14	595,567,564.64	4,710,133,774.43
Тайлант үеийн үр дүн	-	-	133,748,458.52	133,748,458.52
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,347,393,178.65	2,767,173,031.14	729,316,023.16	4,843,882,232.95

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,376,966,500.00	5,408,187,774.09	(31,221,274.09)	100.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,376,966,500.00	5,366,778,074.09	10,188,425.91	99.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,372,946,500.00	5,366,778,074.09	6,168,425.91	99.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,075,178,000.00	3,161,430,585.09	(86,252,585.09)	102.80
210101	Үндсэн цалин	1,707,281,600.00	1,490,799,366.92	216,482,233.08	87.32
210102	Нэмэгдэл	972,511,200.00	1,349,354,234.27	(376,843,034.27)	138.75
210103	Унаа хоолны хөнгөлөлт	139,293,000.00	111,443,778.71	27,849,221.29	80.01
210104	Урамшуулал	256,092,200.00	209,833,205.19	46,258,994.81	81.94
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	415,149,100.00	403,733,103.00	11,415,997.00	97.25
210201	Тэтгэврийн даатгал	292,141,900.00	278,728,001.00	13,413,899.00	95.41
210202	Тэтгэмжийн даатгал	30,751,800.00	31,471,559.00	(719,759.00)	102.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	24,601,400.00	25,183,969.00	(582,569.00)	102.37
210204	Ажилгүйдлийн даатгал	6,150,400.00	6,213,597.00	(63,197.00)	101.03

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Нэгдсэн эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210205	Эрүүл мэндийн даатгал	61,503,600.00	62,135,977.00	(632,377.00)	101.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	635,953,700.00	547,389,039.00	88,564,661.00	86.07
210301	Гэрэл, цахилгаан	81,599,900.00	62,897,165.00	18,702,735.00	77.08
210302	Түлш, халаалт	402,568,000.00	344,299,865.00	58,268,135.00	85.53
210303	Цэвэр, бохир ус	151,785,800.00	140,192,009.00	11,593,791.00	92.36
2104	Хангамж, бараа материалын зардал	91,100,900.00	124,623,645.00	(33,522,745.00)	136.80
210401	Бичиг хэрэг	4,820,000.00	6,920,560.00	(2,100,560.00)	143.58
210402	Тээвэр, шатахуун	55,822,300.00	72,934,625.00	(17,112,325.00)	130.65
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,237,000.00	4,974,610.00	262,390.00	94.99
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	16,736,600.00	35,799,250.00	(19,062,650.00)	213.90
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,485,000.00	3,994,600.00	4,490,400.00	47.08
2105	Нормативт зардал	1,047,527,800.00	1,027,974,882.00	19,552,918.00	98.13
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	882,153,400.00	876,621,901.00	5,531,499.00	99.37
210502	Хоол, хүнс	147,009,600.00	149,451,905.00	(2,442,305.00)	101.66
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	18,364,800.00	1,901,076.00	16,463,724.00	10.35
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	78,448,600.00	51,759,820.00	26,688,780.00	65.98
210601	Багаж, техник, хэрэгсэл	39,720,000.00	4,488,300.00	35,231,700.00	11.30
210604	Урсгал засвар	38,728,600.00	47,271,520.00	(8,542,920.00)	122.06
2107	Томилолт, зочны зардал	8,536,000.00	1,300,400.00	7,235,600.00	15.23
210702	Дотоод албан томилолт	8,536,000.00	1,300,400.00	7,235,600.00	15.23
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,052,400.00	48,566,600.00	(27,514,200.00)	230.69
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	31,420,000.00	(31,420,000.00)	
210803	Даатгалын үйлчилгээ	3,243,000.00	4,327,684.00	(1,084,684.00)	133.45
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	176,000.00	242,000.00	(66,000.00)	137.50
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,311,600.00	7,268,100.00	43,500.00	99.41
210807	Газрын төлбөр	499,700.00	968,616.00	(468,916.00)	193.84
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	7,311,500.00	4,340,200.00	2,971,300.00	59.36
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	41,409,700.00	(41,409,700.00)	
2200	Дотоод эх үүсвэрээр	-	41,409,700.00	(41,409,700.00)	
223001	Бусад хөрөнгө	-	41,409,700.00	(41,409,700.00)	

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,376,966,500.00	5,410,561,748.30	(33,595,248.30)	100.62
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	265,000,000.00	(265,000,000.00)	
131001	Улсын төсвөөс санхүүжих		265,000,000.00	(265,000,000.00)	
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	340,000,000.00	(340,000,000.00)	
133004	төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт		340,000,000.00	(340,000,000.00)	
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,337,418,000.00	4,663,013,339.30	674,404,660.70	87.36
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	5,337,418,000.00	4,663,013,339.30	674,404,660.70	87.36
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	39,548,500.00	142,548,409.00	(102,999,909.00)	360.44
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	39,434,000.00	141,158,109.00	(101,724,109.00)	357.96
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	114,500.00	1,390,300.00	(1,275,800.00)	1,214.24
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		2,373,974.21	(2,373,974.21)	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	201	197.00	4.00	98.01
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	136	143	(7)	105.15
620003	Үйлчлэх ажилтан	64	53	11	82.81
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	201	197	4	98.01
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	137	144	(7)	105.11
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	64	53	11	82.81

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	593,746,040.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	593,116,040.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	328,316,040.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	261,063,600.00
210101	Үндсэн цалин	12,099,289.00
210102	Нэмэгдэл	248,964,311.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,826,810.00
210201	Тэтгэврийн даатгал	22,352,239.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,392,884.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,926,213.00
210204	Ажилгүйдлийн даатгал	468,679.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,686,795.00

2104	Хангамж, бараа материалын зардал	1,525,000.00
210401	Бичиг хэрэг	525,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00
2105	Нормативт зардал	26,475,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	25,000,000.00
210502	Хоол, хүнс	1,475,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,840,000.00
210604	Урсгал засвар	6,840,000.00
2107	Томилолт, зочны зардал	585,630.00
210702	Дотоод албан томилолт	585,630.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	264,800,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	264,800,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	264,800,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	630,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	630,000.00
223001	Бусад хөрөнгө	630,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	593,911,077.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	593,911,077.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	30,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	289,830,890.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	35,076,255.00
1340002	эмд санхүүжилт	239,003,932.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	165,037.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын Нэгдсэн эмнэлэг /цаашид Мандал сумын Нэгдсэн эмнэлэг гэх/-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг бүртгэх, тээврийн хэрэгслийн ашиглалтын дэвтрийг хөтлөх зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Отгонбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сумын Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 09 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Мандал сумын Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Жирэмсэн, төрөлт, төрсний дараах үед эх, ураг, нярайд эмнэлгийн мэргэжилтний үзүүлэх эх барихын тусламж, үйлчилгээ;
- Хүний амь насанд аюултай өвчин эмгэгийг оношлох, эмчлэх, сэхээн амьдруулах, хүндрэхээс сэргийлэхэд чиглэсэн хойшлуулшгүй үзүүлэх эмнэлгийн яаралтай тусламж;
- Гэнэтийн цочмог өвчин эмгэг, осол, гэмтэл, хордлого, жирэмсэн, төрөх, амь тэнссэн үед эмнэлгийн тусламжийг газар дээр нь болон тээвэрлэх явцад үзүүлж, эмнэлэгт хүргэх түргэн тусламжийн үйлчилгээ;
- Өвчин эмгэг бүхий үйлчлүүлэгчийг асран сувилах замаар эрүүл мэндийг дэмжихэд чиглэсэн сувилахуйн дагнасан тусламж, үйлчилгээ;
- Өвчин эмгэг, бусад хүчин зүйлийн нөлөөгөөр бий болсон хүний биеийн бүтэц, үйл ажиллагааны алдагдлын улмаас үүссэн үр дагаврыг арилгахад чиглэсэн сэргээн засах тусламж, үйлчилгээ гэх мэт.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзэж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь төсөв захиран зарцуулагчийн тушаалаар баталгаажаагүй бөгөөд 2019 онд боловсруулагдсан бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцэхгүй, тус байгууллагын үйл ажиллагааны онцлог, хууль журамд орсон өөрчлөлтүүдтэй нийцэхгүй байна. *Итхуйлбал төсвөөс санхүүжилт авахгүйгээр гүйцэтгэлээрээ ЭМДС-гаас санхүүжилт авдаг болсон гэх мэт /*

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод хяналт хийгдээгүй байна.

3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сумын Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.


3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 5,815,757.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу

87,236.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 65,427.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.



3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мандал сумын Нэгдсэн эмнэлгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 677,974.1 мянган төгрөгөөр буюу 14.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, үндсэн хөрөнгийн дансад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		2,539.00	2,539.00
Авлага		336,906.50	336,906.50
Урьдчилгаа			
Бараа материал	256,649.90	217,062.40	(39,587.50)
Үндсэн хөрөнгө	4,453,483.80	4,831,599.90	378,116.10
Нийт хөрөнгө	4,710,133.70	5,388,107.80	677,974.10
Өр төлбөр		544,225.60	544,225.60
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,710,133.70	4,843,882.20	133,748.50
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,710,133.70	5,388,107.80	677,974.10

Тайлант онд мөнгөн хөрөнгө данс нь 2,539.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь төрийн сангийн гүйлгээ хааснаас хойш тушаагдсан 2,373.9 мянган төгрөгийн орлого, нэмэлт санхүүжилтийн дансанд зарцуулах эрх нь үүссэн боловч зарцуулагдаагүй 165.0 мянган төгрөгийн цалин, НДШ зэргээс шалтгаалсан байна.

Авлага дансны үлдэгдэл 336,906.5 мянган төгрөг болж өссөн нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авах дутуу санхүүжилтийн авлагатай холбоотой байна. /Тооцоо нийлсэн актаар/

Бараа материалын дансны үлдэгдэл 217,062.4 мянган төгрөг болж 39,587.5 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 1,550,882.8 мянган төгрөгийн материал худалдан авсан, ЭМЯ, ОНОМ сан болон бусад байгууллагаас 275,358.9 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, 1,865,829.3 мянган төгрөгийн материал зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 5,954,730.3 мянган төгрөг болж 84,975.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 42,039.7 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, ЭМЯ болон бусад байгууллагаас 342,227.6 тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжүүдийг үнэ төлбөргүй хүлээн авсан, өөрийн

орлогоос эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр 6,331.7 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн болон өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой хөрөнгийг 394,691.3 мянган төгрөгөөр үнэлж орлого авч, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 700,314.9 мянган төгрөгийн хөрөнгийн дансны үнийг бууруулсан зэргээс шалтгаалсан байна.

Өр төлбөр данс 544,225.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь Ковид-19 цар тахлын голомтод ажилласан эмч, эмнэлгийн албан хаагчид олгох цалин, НДШ-ийн зардалд 242,798.3 мянган төгрөг, цэвэр бохир усны зардалд 950.3 мянган төгрөг, эм эмнэлгийн хэрэгслийн зардалд 300,476.8 мянган төгрөгийн өглөг үүссэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,843,882.2 мянган төгрөг болж 133,748.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 7,383,572.1 мянган төгрөг болж өмнөх оноос 1,183,064.3 мянган төгрөгөөр буюу 19.1 хувиар өссөн нь Ковид-19 цар тахлын үед ЭМЯ-аас болон иргэд аж ахуй нэгжээс үндсэн хөрөнгө, бараа материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, бүртгэл тайланд тусгасан, Эрүүл мэндийн даатгалаас авах санхүүжилт нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 7,249,823.6 мянган төгрөг болж өмнөх оноос 1,434,066.3 мянган төгрөгөөр буюу 24.6 хувиар өссөн нь Мандал сумын Засаг даргын 2021 оны 06 сарын 21-ний өдрийн А/134 дүгээр албан даалгаврын дагуу үндсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тасгуудыг 20-180 ортой Ковидын эмчилгээний тасаг болгон бэлэн байдлын зэргийг хангаж ажилласантай холбоотой байна. Өмнөх оноос дараах зардлууд өссөн байна. Үүнд:

- Цалин, НДШ-ийн зардал 606,184.7 мянган төгрөг,
- Цэвэр, бохир усны зардал 44,786.3 мянган төгрөг,
- Тээвэр шатахуун 30,491.6 мянган төгрөг,
- Шуудан холбоо интернэтийн зардалд 2,281.7 мянган төгрөг,
- Эм, эмнэлгийн хэрэгслийн зардалд 394,134.0 мянган төгрөг,
- Хоолны зардалд 32,318.2 мянган төгрөг,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 31,624.8 мянган төгрөг,
- Бусад сумаас дайчлагдан ажилласан эрүүл мэндийн багийн цалин болон бусад зардалд 31,654.0 мянган төгрөг
- Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардалд 260,591.0 мянган төгрөг гэх мэт.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Гүйцэтгэл
Төсвийн
Хүрээ
Төсвийн
Хүрээ
Төсвийн
Хүрээ

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлэхээр 6,992,554.3 мянган төгрөгөөр тооцон төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 1,615,587.7 мянган төгрөгөөр бууруулж, **5,376,966.5 мянган** төгрөгөөр баталсан бөгөөд цалин, НДШ-ийн зардлыг 924,851.2 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 297,253.4 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 267,335.0 мянган төгрөгөөр, бусад зардлыг 126,148.1 мянган төгрөгөөр тус тус бууруулж баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн эмнэлгийн тусламж үйлчилгээг хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 1 арга хэмжээг эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлэхээр **5,410,561.7 мянган** төгрөгийн зарцуулалтын эрхийг баталснаас **5,408,187.8 мянган** төгрөгийг зарцуулсан байна.

Гүйцэтгэлээр ЭМД сангаас 5,268,013.3 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 141,158.1 мянган төгрөг /ор хоног, урьдчилан сэргийлэх үзлэгийн төлбөр/, туслах үйл ажиллагааны орлогоос 1,390.3 мянган төгрөг, нийт 5,410,561.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 5,408,187.8 мянган төгрөгийг зарцуулж, 2,373.9 мянган төгрөгийг мөнгөн хөрөнгийн дансанд эцсийн үлдэгдлээр тайлагнасан байна.

Орлого, зарлагын гүйцэтгэлийг зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд нийт **593,911.0** мянган төгрөг төвлөрсөн байна. Үүнд: ЭМЯ-аас ЭМС-ын А/496, А/585 дугаар тушаалаар олгосон нэг удаагийн тэтгэмжийн санхүүжилтэд 264,800.0 мянган төгрөг, ЭМД-ийн сангаас Ковид-19 санхүүжилт 239,003.9 мянган төгрөг, Хэрх тосгоны ЭМТ-өөс ковидын илүү цагийн хөлс 14,957.3 мянган төгрөг, ЭМГ-аас ЭМС-ын А/415 дугаар тушаалаар илүү цагийн хөлс олгохоор 7,487.9 мянган төгрөг, томилолтын зардалд 585.6 мянган төгрөг, Азийн хөгжлийн сангаас сургалтын зардалд 2,000.0 мянган төгрөг, Бороо гоулд ХХК-аас хандив 30,000.0 мянган төгрөг, урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний төлбөр 35,076.3 мянган төгрөг тус тус төвлөрсөн байна.

Төвлөрсөн орлогоос Ковид-19-ийн үед дайчлагдан ажилсан эмч, эмнэлгийн албан хаагчдад 292,890.4 мянган төгрөгийн илүү цагийн хөлс, эм, эмнэлгийн хэрэгслийн зардалд 25,000.0 мянган төгрөг, хоол, хүнсний зардалд 1,475.0 мянган төгрөг, хангамжийн материалын зардалд 1,525.0 мянган төгрөг, урсгал засварт 6,840.0 мянган төгрөг, томилолтын зардалд 585.6 мянган төгрөг, багаж, хэрэгслийн зардалд 630.0 ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардалд 264,800.0 мянган төгрөгийг буюу нийт **593,746.0** мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, жилийн эцэст 165.0 мянган төгрөг зарцуулагдаагүй үлдэгдлээр тайлагнагдсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.7.1 2021 оны санхүүгийн тайланд тусгагдсан ЭМДС-аас авах 336,906.5 мянган төгрөгийн авлага болон 2021 оны 12 дугаар сарын 10-аас 31-нийг хүртэлх хугацаанд үзүүлсэн тусламж үйлчилгээний 294,599.2 мянган төгрөгийн санхүүжилт зэрэг нийт 631,505.7 мянган төгрөгийн эх үүсвэрээр тайлант оны эцэст тайлагнагдсан 544,225.6 мянган төгрөгийн өр төлбөрийг бүрэн барагдуулах боломжтой байна.

Гэвч тайланд онд ЭМДЕГ-тай байгуулсан гэрээний дагуу ЭМД-ын сангаас авах санхүүжилтийг 12 дугаар сарын 10-аар тасалбар болгон санхүүжилтийн авлагыг дутуу тайлагнаж байгаа нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх “Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2: “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “Тасалбар болголт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Цаашид дээрх хууль тогтоомжуудыг мөрдөж, санхүүгийн тайланд санхүүжилтийн авлагыг бүрэн тусгах шаардлагатай байна.

3.7.2 ЭМС-ын 2021 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн А/567 дугаар тушаал, 09 дүгээр сарын 13-ны өдрийн 1а/4901 дугаар албан бичгээр ахлах нягтлан бодогч, тооцооны нягтлан бодогч, эмийн нярав зэрэг 3 санхүүгийн ажилтнуудад 50-100 хувийн үндсэн цалинтай тэнцэх буюу 1,593.9 мянган төгрөгийг санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт авсан гэх үндэслэлээр урамшуулал цалин олгосон байна.


Тухайн албан тушаалтнууд холбогдох хууль эрхийн актын дагуу улирал бүр ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал авч байхад санхүүгийн тайлангаар “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан, санхүүгийн үйл ажиллагаа сайн гэх үндэслэлээр буюу улирлын ажлын үр дүнгийн зөвхөн 1 үзүүлэлтийг үндэслэн урамшууллыг давхардуулан олгох шийдвэрийг төсвийн ерөнхийлөн захирагчийн зүгээс гаргахгүй байх нь зүйтэй юм.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.



3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 119 мэдээллээс 108 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 11 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансны мэдээллийг бүрэн байршуулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 933.0 мянган төгрөгийн 2 зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 42,068.3 мянган төгрөгийн 2 зөрчилд 1 албан шаардлага, цаашид анхаарах, давтан гаргахгүй байх 5,250.0 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өгснийг бүрэн биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт	2	933.0	2	933.0	100
Албан шаардлага	2	42,068.3	2	42,068.3	100
Зөвлөмж	4	5,250.0	4	5,250.0	100
Нийт дүн	8	48,251.3	8	48,251.3	100

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 52,185.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 33,527.2 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 18,657.8 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах 2 зөвлөмж өглөө.

4.1 Албан шаардлага

1. Тайлант оны нэмэлт орлого буюу түргэвчилсэн тестийн үнийн зөрүүгийн 30,000.0 мянган төгрөгийн орлогыг төрийн санд тушаалгүй, зарцуулалтын эрх үүсгэлгүй урсгал засвар болон хөрөнгийн зардалд зарцуулсан байгаа нь Төсвийн

тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 “Төсвийн байгууллага төвлөрүүлсэн төсвийн орлого болон өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна.”, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.6-д “Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-аас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг / түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй / ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана.”, 2019 оны 74 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын 1.4 “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогын зарцуулалт, тайлагналтыг Төрийн сангаар дамжуулан гүйцэтгэнэ.”, 4.3 “Энэ журмын 3.1.2-т заасан төсвийн жилийн дундуур шинээр бий болсон нэмэлт орлогыг зарцуулах хүсэлтийг төсвийн санхүүжилтийн асуудал хариуцсан нэгж ... хүлээн авч хянасны үндсэн дээр тухай бүр нэмэлт төсвийн зарцуулалтын эрх нээж санхүүжүүлнэ” гэсэн заалтуудтай нийцээгүй ба санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна..

Шийдвэрлэсэн нь: Өөрийн орлогыг Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тухай бүр тушааж, шаардлагатай тохиолдолд холбогдох журмын дагуу зөвшөөрөл авсны үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэх албан шаардлага хүргүүлэх.

2.Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас тайлант онд 2,576.9 мянган төгрөгийн ХХОАТ-ийн авлага, 950.3 мянган төгрөгийн цэвэр, бохир усны өглөг үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;” гэсэн заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр тооцоо, гүйлгээг гарахаас өмнө нь хянан баталгаажуулж байх, өр, авлагыг барагдуулах албан шаардлага хүргүүлэх.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

1.1.1 Илрүүлэлт: Тайлант онд 18,657.9 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтыг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн

баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.1.2 Өгсөн зөвлөмж: Цаашид төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Авто тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дэвтэр хөтөлж, авто машинуудад хийгдсэн урсгал болон их засварын ажлуудыг бүртгэж, холбогдох байгууллагаар баталгаажуулаагүй, тайлант жилд явсан гүйлт км, зарцуулсан шатахууны тооцоог бүрэн бүртгээгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Стандартчилал, Хэмжил зүйн үндэсний зөвлөлийн 2011 оны 51 дүгээр тогтоолоор баталсан заавал мөрдөх “Авто тээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ засварын тогтолцоо, тодорхойлолт” MNS 4601-2011 стандартыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Цаашид Авто тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дэвтрийг хөтөлж, урсгал болон их засвар, нийт км, шатахуун зарцуулалтуудын тооцоог бүрэн бүртгэн, авто механикийн хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Мандал сумын Нэгдсэн эмнэлэг	4	52,185.0	-	-	-	-	2	33,527.2	2	18,657.8